

Дундад зууны үеийн булшны археологийн олдвороор бүрдүүлсэн мэдээллийн сангийн үр дүнгээс

Очирпүрэвийн Мөнхцэцэг 

Соёл, урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ ахисан түвшний
хөтөлбөрийн алба, Улаанбаатар, Монгол Улс
✉ munkhtsetseg1111@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол нутагт малтсан монгол булшнаас олдсон олдворын мэдээлэл, зан үйлийн талаар тоймлон авч үзэв. СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэнд хэрэгжсэн “Монголын эзэнт гүрний үеийн монголчуудын үнэт зүйлс, соёл сэтгэлгээг баримтаар мөшгөх судалгаа” суурь судалгааны төслийн (2022-2024) хүрээнд боловсруулсан “Дундад үеийн монголчуудын оршуулгын соёлын мэдээллийн сан”-д багтсан археологийн олдворуудыг нэгтгэн дүгнэлт хийв. Судалгаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр малтсан дундад зууны үеийн монголчуудын оршуулгын дурсгалын хээрийн судалгааны тайлангууд, мэргэжлийн сэтгүүл, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, нэгэн сэдэвт болон хамтын бүтээл, эрдмийн зэрэг горилсон бүтээлүүдээс холбогдох хэрэглэгдэхүүнийг шинжлэн археологийн судалгааны өгөгдөл (байрлал, дагалдуулсан малын яс) үүсгэв. Соёлын газар зүйн онолын үзэл баримтлалд тулгуурлан бүс нутгийн археологийн соёлын харьцуулалтын арга зүйгээр судалж, судалгааны мэдээллийг боловсруулахад задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалтын аргыг ашиглав. Монгол булшны тархалтын хүрээг газар зүйн байршлаар нь найман ай савд хуваан үзэж, тус бүрийн онцлог шинжийг тодруулан үзүүлэх оролдлого хийж, монгол оршуулгын соёлын зарим үзүүлэлтийг харьцуулж үзэв.

Түлхүүр үгс: *эд өлгийн зүйлс, хойлгын мал, бүс нутаг, олдворын мэдээлэл*

The results of a database of medieval tombs archaeological finds

Munkhtsetseg Ochirpurev 

Research and Advanced program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ munkhtsetseg1111@gmail.com

Abstract: The research consolidates findings from the “Database of Medieval Mongolian Burial Culture,” which was developed as part of the foundational research project “Tracing Mongolian Values, Culture, and Thought During the Mongolian Empire Period Through Documentary Evidence” at the Institute of Culture and Arts Research

under the Mongolian National University of Arts and Culture. The study analyzes data from field research reports on medieval Mongolian burial monuments excavated within Mongolia, scholarly articles published in professional journals and compilations, monographs, collaborative works, and academic dissertations. Methodologically, the research employs analytical, synthesis, and comparative approaches. The geographical distribution of Mongolian burials has been categorized into eight regional zones, with an attempt to identify the distinctive characteristics of each region and to compare various aspects of Mongolian burial culture.

Keywords: *artifact, sacrificial animals, region, archaeological data*

Оршил

Монгол нутагт амьдран байсан эрт, дундад үеийн малчин нүүдэлчдийн үлдээсэн булш дурсгалаас чухам хэн нь монголчуудын өвөг дээдэс болох, түүнийг илтгэх угсаа, соёлын биет хэрэглэгдэхүүн, зан заншил өнөө цагийн монголчуудад хэрхэн өвлөгдсөн тухай асуудал сонирхолтойгоос гадна Монгол Улсад бие даасан археологийн малтлага судалгаа хийгдэх болсон цагаас соёлын биет болон биет бус өвийн эх сурвалж хэрэглэгдэхүүн судалгааны эргэлтэд орж, шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмрээ оруулсаар байгаа билээ. “Монгол оронд амьдарч байсан овог аймгууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн, нүүдэлчдийн өвөрмөц соёл иргэншлийг үүсгэн буй болгож, баяжуулан хөгжүүлж иржээ. Нүүдлийн мал аж ахуйтай болсноор хүмүүсийн хөдөлгөөн, харилцаа хөгжиж эдийн засаг, соёлын хэлхээ холбоо ихээхэн түгээмэл болсон” (ШУА 2003, 9). Үүнийг археологийн судалгаагаар улам бүр батлан харуулсаар байгаа билээ. Археологийн судалгаа эрчимжиж байгаа хэдий ч олдвор, эд өлгийн зүйлсийг соёл, урлаг судлалын талаас нарийвчилсан судалгаа дутагдалтай байгаа нь илэрхий байна. Иймээс ч бид Эзэнт гүрний үеийн монголчуудын оршуулгын соёлын мэдээллийн санг бүрдүүлэх нь “тухайн цагийн монголчуудын оршуулгын зан үйл төдийгүй байгаль, ертөнцийн тухай мэдлэг төсөөлөл, итгэл үнэмшлийн тогтолцоо, ахуй байдал, хөдөлмөрийн хуваарь, анги давхраажилт, соёлын гадаад харилцаа, дотоод холбоо хамаарал төдийгүй уламжлалт урлахуй ухаан буюу мужаан, дархан, уран үйл урлалын хөгжлийн төвшин, тэдгээрийн орон нутгийн ялгаа, онцлогийг нэгтгэн үзэх нь чухал ач холбогдолтой” (Өлзийбаяр, Мөнхцэцэг 2025, 38) хэмээн үзсэн билээ. Мэдээллийн санг бид Соёл, урлаг судлалын хүрээлэнд хэрэгжсэн суурь судалгааны төслийн хүрээнд хийсэн ба Монгол нутагт малтан судалсан дундад зууны үеийн булш оршуулгын хэрэглэгдэхүүнд задлан шинжилгээ хийж, оршуулгын зан үйл, илэрсэн эд өлгийн зүйлс, хойлгын малын төрлөөр зүйлчилсэн нь 1920-оод оноос 2020 он хүртэлх 100 жилийн хугацаанд малтлагаар илэрсэн булш, оршуулгын зан үйл, соёлын өвийг нэгтгэн харах боломжийг тодорхой хэмжээнд олгох ажил болсон.

Судалгааны арга зүй

Эх хэрэглэгдэхүүн судлал, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалтын аргыг хэрэглэсэн болно.

Судалгааны үр дүн

Өнөөгийн байдлаар Монгол орны нутаг дээр барагцаалбал 800 гаран монгол булш малтсан тойм тоог судлаачид дурдсан байдаг. Эдгээрээс 70% гаруйг дээрх мэдээллийн санд багтаасан ба газар орон, дундаж гүн, оршуулгын зонхилох чиглэл, хойлгын шүүсэнд хонины шаант чөмөг, нугалам нуруу болон дал оролцуулсан байдал, модон бүтэцтэй эсэх зэрэг зан үйлийн илэрхийлэгч болох голлох үзүүлэлтийг чухалчлан авч үзсэн.

Монгол нутгаас олдсон хамгийн анхны монгол булш хэмээн тодорхойлсон булш 1960 онд Н.Сэр-Оджав, А.П.Окладников, Д.Дорж, Ц.Доржсүрэн, В.В.Волков нарын оролцсон Монгол-Зөвлөлтийн хамтарсан Чулуун зэвсгийн үе судлах анги Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Хар Аргалант ууланд малтсан нэгэн булш юм. Энэ булшийг мэдээ зангийг хураангуйлан тодорхойлбол,

хойшоо чиглэлтэй, хүнээ тэнэгээрээр хоёр хөлийг жийлгэж, хоёр гарыг биеийг нь дагуулан сунгасан, австай. Хар-Аргалант уулын ард, баруун урагш харсан гүнзгий жалганы урд талын налуувтар эргийн дунд хирд олдсон (уул авсыг ганга жалганы эргийн ирмэг дээр анх булсан нь хожим эргийн хамт цөмөрч доош гулгаж нурсан эсхүл ерөөсөө жалганы налуувтар эрэгт булсан алин болохыг одоо тодорхойлох аргагүй). Жижиг дөрвөлжин ширэн хавтага (хавтаганы хамхих дөрдгөр амсрын үзүүрт утсан оосор хийж түүгээр уул хавтагыг ороосон), түүний дотор жижиг хэтний гангийн хугархай, хэдэн цахиур байсны зэрэгцээ хөл хооронд модон иштэй төмөр хутга, хүний ясны дор бүдүүн бөс барааны үлдэгдэл олдсон бөгөөд нарийвчлан үзвэл, ногоон өнгийн эдээр хийсэн дээлийн тасархай бололтой байв. Хүний ясны баруун гар талд ширэн хоромсоготой, нимгэн арьсаар оёж бүрсэн наамал модон нум, нумын хөвчийг үсийг нь сайн хусаж арилгаагүй, нойтон арьсаар мушгиж хийсэн байлаа. Мөн үйсээр хийсэн нарийвтар гүнзгий саадганд шилбэтэй дүгрэг ба шовх үзүүртэй төмөр зэвтэй хэдэн сум байв. Авсны таг дээр улаан будагтай эмээлийн мод байсан ба энэ эмээлийн нэг хавтас нь хуучин хугархай байснаас гадна суудлын зарим жижиг мод ерөөсөө үгүй байгааг үзэхэд уул эмээл нь нас барагчийг амьд байх цагт эвдэрч муудсан бололтой. Эмээлийн урд бүүрэгний орой нь дөрвөлживтөр бөгөөд хойт, урд бүүрэгний нүүрэнд тус бүр нэжгээд төмөр цагариган гогцоо хадсан нь түүнээс ямар нэгэн зүйл уяхад зориулсан бололтой. Бүүрэг хавтсыг ширэн үдээсээр үдэж бэхэлжээ. Хавтсанд ганзаганы сурны нүхнүүд гаргасан байна. Мөн жижиг төмөр товруу хаджээ. Эмээлийн модонд дөрөөний сурны нүх байгаа боловч дөрөөгүй байгааг үзэхэд ерөөсөө дөрөөгүй эмээл хийж оршуулсан бололтой байна (Волков 1962).

Харин 2010 оноос эхлэн энэ бүс нутагт авран хамгаалахмалтлагын ажил эрчимжиж олон тооны монгол булш илрүүлсэн байдаг. Монгол булшны талаар Х.Лхагвасүрэн 1994 онд “Средневековые погребения монголов (XII-XIV вв.)” түүхийн ухааны эрдмийн зэрэг горилсон бүтээл, 2007 онд “Монголын археологи (Чингэс хааны үе)” нэгэн сэдэвт бүтээл, 2007 онд У.Эрдэнэбат “Монгол Улсын нутаг дэвсгэрт дундад зууны монголчуудын булш, оршуулгын дурсгалыг судалсан тойм”, 2024 онд Б.Батдалай “X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол Улсад малтсан хэрэглэгдэхүүнээр)” эрдмийн зэрэг горилсон бүтээл бичжээ.

Х.Лхагвасүрэн эрдмийн зэрэг горилон бичсэн бүтээлдээ монгол булшны судалгааны түүхийг нэгтгэж (Лхагвасүрэн 1994), 2007 онд тухайн цагтаа Монголд судлагдсан монгол булшны хэрэглэгдэхүүнийг бүс нутгаар хуваан, мэдээллийн сан бүрдүүлсэн (Лхагвасүрэн 2007) бол У.Эрдэнэбат тухайн цагт мэдэгдээд байсан 231 чулуун овоолго бүхий булш, 38 хадны оршуулгын судалгааны түүхийг (Эрдэнэбат 2007), харин Б.Батдалай 2007-2020 онд малтсан монгол булшны судалгааны түүхийг тус тус бичжээ (Батдалай 2024).

Нийт бүс нутгаас олдсон монгол булшны олдворын хувьд тодорхой давтамжтай олддог эд өлгийн зүйлсийг түүвэрлэн үзвэл, эрэгтэй хүнд ихэвчлэн зэр зэвсэг, малын тоног хэрэгсэл, саадаг, хоромсого, төмөр хутга, аяга, хавтагыг, эмэгтэй хүнд богтаг малгай, хүрэл толь, сам, төмөр хутга, гоёл чимэглэлийн зүйлс, аяга, бөс даавуу зэргийг дагуулдаг байна. Түгээмэл олдсон малын ясны тухайд шагай чөмөг болон шагай, дал, нурууны яс ихэнх булшнаас байршлын хувьд харилцан адилгүй, харин нурууны яс 2-4 үетэйгээр дийлэнхдээ хүний нуруун тушаа доороос олдох нь нэлээд нийтлэг байна.

Монголд малтсан монгол булшуудыг газар нутгийн онцлог, хамрах хүрээнээс шалтгаалан Хэрлэн, Онон, Туул, Сэлэнгэ-Тэсийн (Эг, Хөвсгөл хамт), Орхон-Тамир, Алтайн, Тал хээрийн, Говийн хэмээн найман ай сав, бүс нутгаар хуваан ангилж, малын яс болон булшны мэдээллүүдийг харьцуулан хүснэгтээр харахад бидний бүсчилсэн газар нутагт дээрх мэдээллүүд харилцан адилгүй өөр өөр байна.

Хүснэгт 1. Хэрэглэгдэхүүний харьцуулалт (бүс нутгаар)¹

Бүс	Газрын тоо	Булш	гүн см	Чиглэл (%)			Шаант чөмөг	Нугалам нуруу	Дал	Авс
				х	бх	зх				
Хэрлэн	22	74	106	54	12.5	27	30	15	12	30
Онон	2	3	150	50	50	-	-	33	-	
Туул	4	10	153		33	67	40		20	
Сэлэнгэ-Тэсийн (Эг, Хөвсгөл хамт)	32	115	102	26	12	51	42	27	6	31
Орхон-Тамир	15	35	118	28	48	4	20	17	6	40
Алтайн	12	14	103	21	7	7	7	-	-	14
Тал хээрийн	30	224	97	41	31	25	42	19	20	41
Говийн	40	94	108	25	61	9	34	15	4	55

Судлагдсан дурсгалт газар, булшны тоо хэмжээгээр Тал хээр ба Говийн бүс нутаг дийлэнх хувийг эзэлж байгаа нь сүүлийн жилүүдэд авран хамгаалах судалгаа түлхүү хийгдэж байгаатай холбоотой. Ай сав, бүс нутгаар хуваасан булшны мэдээллийг тус бүрчлэн тоймлон, тухайн бүс нутгийн булшны онцлогийг доор харуулав.

Хэрлэнгийн сав газар: Нийт 22 газрын 74 булшнаас гүн нь мэдэгдэж байгаа булш 74,57% байгаагийн дундаж гүн 98,84 см, 100 см-ээс илүү гүнтэй булш 50%,

¹ Өлзийбаяр С., Мөнхцэцэг О. 2025. “Монгол булшны судалгааны түүхийн үечлэл ба дундад үеийн монголчуудын оршуулгын соёл мэдээллийн сангийн үзэл баримтлал.” *Эзэнт гүрний үеийн монголчуудын үнэт зүйлс, соёл, сэтгэлгээг баримтаар мөшгөхүй*, Ер. ред. Алтанцэцэг Ч., Ред. Энхчимэг Ц., Золзаяа М. Улаанбаатар: Соёмбо принтинг.

100 см-ээс бага гүнтэй булш 50%-ийг эзэлж байна. Хэрлэнгийн сав газраас малтсан булшнаас хүнээ харуулж тавьсан чиглэл мэдэгдэж байгаа булш нийт булшны 66,1% нь байгаа ба үүнээс хойшоо чиглэлтэй булш 59%-ийг эзэлж байна. Харин баруун хойшоо болон зүүн хойшоо чиглэлтэй булш тус тус 17.9%, бусад чиглэл рүү хандуулсан нь 5,12% байна. Авс хашлага зэрэг модон бүтээцийн үлдэгдэл энэ сав газарт малтсан монголын үеийн нийт булшны 28,81%-д байгаа бол үлдсэн 71,19% нь ямар нэгэн байгууламжгүй шууд нүхэнд тавьсан болон авсны мэдээлэл байгаагүй булш байна. Шагайт чөмөг нь ихэвчлэн богийн шагайт чөмөг байх ба босоо, хэвтээ, шагайг дээш харуулсан, доош харуулсан зэргээс гадна эр, эм, хүүхдийн булшнаас ялгалгүй олдсон байна. Олонх нь толгойн талаас олдсон нь ажиглагдаж байна. Энэ төрөлд борвийг хамруулж, харин шагайг тусад нь авч үзэв. Нийт булшны 27,11%-д нь шагайт чөмөг дагалдуулсан. Харин эрэгтэй, эмэгтэй хүнд хэдэн хувиар дагалдуулсан байгаа нь нийт булшны эрэгтэй эмэгтэйн ялгаа бүрэн тодорхой биш учир тодорхойлох боломжгүй байна. Зөвхөн шагай тусдаа нийт булшны 3,38%-аас олджээ. Шагайт чөмгөнөөс гадна бог малын нурууны нугалам дагалдуулсан нь элбэг байна. Энэ сав газарт малтсан булшны 8,47%-д нурууны нугалам хоёр ба гурван үеэр нь, бүгдэнд нь хүний нурууны орчим доор нь тавьсан нь илэрчээ. Харин дал яс нийт булшны 11,86%-аас илэрчээ. Дийлэнхдээ бог малын далны яс байх боловч энд нэг булшнаас үхрийн далны яс илэрснийг хамтатган үзэв. Дээрх яснуудаас гадна богийн бусад яс илэрсэн булш нийт булшны 5,08% байна. Богтаг малгай, богтаг малгайн чимэглэл, богтаг малгайн үйсний хэсэг олдсон булш нийт булшны 22,03% байгаа ба толгойн зүүн, баруун талд тавьсан байх нь элбэг. Төмөр хутга зөвхөн эрэгтэй хүний булш төдийгүй эмэгтэй хүний булшнаас ч олдсон ба нийт булшны 11,86%-аас модон иштэй, хуйтай зэрэг төрлөөр олджээ. Харин үйлийн хайчийг эмэгтэй хүний булшнаас олддог хэмээн үздэг боловч үүнийг энд тодорхойлох боломжгүй байна. 10,16%-д нь үйлийн хайч, 6,77% хоромсого болон төмөр дөрөө тус тус олджээ.

Ононгийн сав газар: Энэ бүс нутагт 2 газрын 3 булшны 77,8%-ийнх нь булшны гүн мэдэгдэж байгаа ба дундаж гүн нь 131,6 см байна. Үүнээс 100 см-ээс гүн булш 78,6%, 100 см хүрэхгүй гүнтэй булш 21,4% нь байна. 66,7% булшинд хүнээ хандуулсан чиглэл тодорхой байгаагаас 33,4% нь хойшоо чиглэлд байна. Авс хашлага зэрэг модон бүтээцийн мэдээлэл 38,9%-д байсан ба үлдсэн 61,1% нь авсгүй болон авсны талаарх мэдээлэл малтлагын тухай тэмдэглэл, тайланд дурдагдаагүй болно.

Дагуулсан малын ясны тухайд 11,1% шагайт чөмөг, мөн 11,1%-д нь дан шагай дагалдуулсан, 16,66%-д нь богийн дал, 27,77%-д нь дунд чөмгөний яс (чөмгөний яс), 22,22%-д богийн нурууны 3 нугалам яс цээжин доор, 11,1%-д нь адууны шүд олдсон байна. Эд өлгийн зүйлийн хувьд 11,1% нь богтаг малгайн үлдэгдэл, 27,77%-д нь хутга, 16,66%-д нь төмөр хайч, 11,1%-д нь хоромсого, мөн 11,1%-д нь төмөр дөрөө илэрчээ.

Туулын сав газар: Дөрвөн газрын 10 булшнаас 40%-ийн гүн мэдэгдэж байгаа ба дундаж гүн 152,5 см. Эдгээр гүн тодорхой булшны 75% нь 100 см-ээс дээш гүнтэй, 25% нь 100 см-ээс бага гүнд байрлана. Нийт булшны 30%-ийн чиглэл тодорхой байгаагаас 66,6% нь зүүн хойшоо, 33,3% нь баруун хойшоо чиглэжээ.

Авс хашлаганы үлдэгдэлтэй булш болон австай хэмээн мэдээлсэн булш нэг ч байсангүй. Шагайт чөмөг нийт булшны 40%-д, богийн дал 20%, богтаг 10%, дөрөө 40%-д, хутга 40%-д, төмөр хайч 10%, хоромсого 30%-д нь дагалдуулжээ.

Сэлэнгэ-Тэс (Эг, Хөвсгөл хамт): 32 газрын 115 булшнаас гүн нь тодорхой булш 88,7% байгаагаас 100 см-ээс дээш гүн нүхнээс олдсон булш 47%, 100 см-ээс бага гүнээс олдсон булш 53% байна. Нүхний дундаж гүн 102,35 см. Хүнээ хандуулсан чиглэл 74% булшинд мэдэгдэж байгаа бөгөөд хойшоо чиглэлтэй булш үүний 25,9%-д, баруун хойшоо чиглэсэн нь 11,8%-д, зүүн хойшоо чиглүүлсэн нь 50,6%-д, зүүн тийш 8,2%, баруун 1,1%, баруун урагшаа чиглүүлсэн нь 2,4% тус тус байна. Авс хашлаганы үлдэгдэлтэй булш 31,3%-ийг эзэлж үлдсэн нь ихэнхдээ авсгүй олдсон булш байна. Шагайт чөмөг ба шагай илэрсэн булш нийт булшны 41,73%, хонины дал 6,08%, хонины нурууны яс 26,95% байгаа бол бусад яс 27,82%-д илэрчээ. Бусад яс гэдэгт хонины хүзүүний яс, хонины толгой, шийр, сүүж, адууны яс зэрэг бод богийн яснууд байхаас гадна бугын яс багтжээ. Дагалдуулсан эд зүйлсийн хувьд богтаг малгай 0,86%, төмөр хутга 15,65%, үйлийн хайч 5,21%, дөрөө (дан болон хос) 4,35%, хоромсого мөн 4,35%-д нь олдсон байна.

Орхон (Тамир хамт): Энэ сав нутагт 15 газрын 35 булшнаас гүн нь мэдэгдэж байгаа булш 82,85%, үүний дундаж гүн нь 117,72 см байна. 100 см-ээс дээш гүнтэй булш 65,5% 100 см-ээс бага гүнтэй булш 34,5% байна. Хүнээ хандуулсан чиглэлийн хувьд 71,4% нь чиглэл тодорхой байна. Үүнээс хамгийн их буюу 48% нь баруун хойшоо, 28% нь хойшоо байхад ердөө 4% нь л зүүн хойшоо чиглэжээ. Харин баруун тийшээ 12% нь, баруун урагшаа 8% нь чиглэсэн байгаа нь нэлээд онцлог байна. Авс, модон хашлаганы үлдэл нийт булшны 40%-д илэрсэн. Шагайт чөмөг илэрсэн булш нийт булшны 20%, шагай 2,86%, хонины дал 5,71%, хонины нурууны яс (2, 3, 4 нугаламтай) 17,1% байгаа бол бусад яс 25,7%-д илэрчээ. Бусад яс гэдэгт хонины хүзүүний яс, хонины толгой, шийр, сүүж, бүтэн адууны хэлхээ яс зэрэг бод богийн яснууд байхаас гадна гөрөөсний хоёр нурууны яс багтжээ. Дагалдуулсан эд зүйлсийн хувьд богтаг малгайн байж болох үйсний хэсэг 20%, төмөр хутга болон үйлийн хайч тус бүртээ 14,3%, хоромсого 5,7%-д нь олдсон байна.

Алтайн: Алтайн бүс нутагт 12 газрын 14 булшны 64,28%-ийн гүн тодорхой байгаа ба дундаж гүн 103,33 см. Үүнээс 100 см-ээс дээш гүнтэй булш 66,6%, 100 см-ээс бага гүнтэй булш 33,4%-ийг эзэлж байна. Хүнээ хандуулсан чиглэлийн мэдээлэл 35,7%-д байгаагаас 21,4% нь хойшоо, тус тусдаа баруун хойшоо болон зүүн хойшоо хандсан булш 7,14% байгаа нь харьцааны хувьд ижил байна. Авс хашлаганы үлдэгдэлтэй булш нийт булшны 14,2%-ийг эзэлж байна. Нийт булшинд дагалдуулан тавьсан зүйлсээс хонины шагайт чөмгийг ердөө 7,14%-д, шагайг 14,28%-д, богтаг малгайг 7,14%-д, хутга 14,28%, хайч мөн адил 14,28%-д хоромсого 7,14%-д дагалдуулсан нь бусад газрын дагуулсан зүйлсээс харьцангуй бага байна.

Тал хээрийн (Дорнодын Хэрлэнгээс урагш, Сүхбаатар, Чойр, Дорноговийн хойгуур, Дундговь, Хангайн урдуур, Онгийн сав зэрэг): Тал хээрийн бүсэд хамааруулсан 30 газрын 224 булшнаас гүн тодорхой булш 91,96%-ийг эзэлж байгаа нь бусад газраас хамгийн их гүнийг тодорхой дурдсан, эсвэл гүн тодорхойлох

боломжтой байсан нь харагдана. Үүнээс 100 см-ээс дээш гүнтэй булш 58,25% нь, харин 100 см-ээс бага гүнд илэрсэн булш 41,75% нь байна. Дундаж гүн 97,3 см. Хамгийн гүн булш нь 320 см байхад хамгийн гүехэн буюу 25-30 см-аас илэрсэн булш хэд хэд байна.

Хүнээ хандуулсан чиглэлийн хувьд нийт булшны 66,96% нь чиглэл тодорхой байгаагаас дийлэнх нь хойшоо хандсан байна. Нарийвчлан авч үзвэл, хойшоо 40,67%, баруун хойшоо 31,33%, зүүн хойшоо 25,33%, баруун 2%, зүүн тийшээ 0,67%-ийг эзэлж байна. Авс, модон хашлаганы үлдэгдэл мэдэгдэж буй булш 40,6% байгаа ба бусад булшинд тодорхой мэдээлэл байсангүй. Шагайт чөмөг дагуулсан булш 41,5% нь байна. Энэ сав газар шагайт чөмгийг хүнийхээ зүүн урд байрлуулсан нь нэлээд байгаа нь бусад газрын булшнаас онцгойрч байна. Далыг 19,6%-д нь дагуулжээ. Далыг харин шагайт чөмгөөс эсрэгээрээ дийлэнхдээ хүнийхээ дээд хэсэгт байрлуулсан байгаа ч мөн шагайт чөмөгтэй цуг тавьсан булш ч байна. Харин нурууны ясыг бусад газрын ижил дийлэнхдээ хүнийхээ нурууны доор байршуулсан байгаа ба нийт булшны 18,7%-аас нь илэрчээ. Харин энэ бүс нутагт малын бусад яс, бод малын яс, мөн зэрлэг амьтны яс дагалдуулсан нь нэлээд их байгаа нь ажиглагдлаа. Жишээлбэл, адууны шүд, үхэр тэмээний толгой, дөрвөн шийр, цагаан зээр, хар сүүлт зээр, хулангийн яс гэх мэт. Ийм төрлийн яс олдсон булш 36,1%-д нь байна. Богтаг малгай илэрсэн булш 11,6% байгаа бөгөөд богтаг малгай гэж тодорхой дурдаагүй үйсний хэсгүүд олдсон булшийг энд хамруулаагүй болно. Харин хутга олдсон булш 20%, төмөр хайч олдсон булш 11,1%, төмөр дөрөө нэгээр болон хосоор олдсон булш 8,5%, хоромсог олдсон булш 1,3% тус тус байна. Энэ хэсгийн газраас бүрэн хэрэглэлтэй морь олдсон булш мөн илэрсэн байна.

Говийн бүс: Говийн бүс нутагт хамруулан хуваасан нийт 40 газрын 94 булшны гүн мэдэгдэж байгаа булш 89,4% байна. Үүнээс 100 см-ээс дээш гүнтэй булш 63,1%, бага гүнтэй булш 36,9% байна. Гүн тодорхой булшнуудын дундаж гүн 107,94 см ажээ. Чиглэл тодорхой булш 81,9% байгаагаас баруун хойшоо 61,1% нь, хойшоо чиглэлтэй 24,7%, зүүн хойшоо чиглэлтэй 9%, харин баруун чиглэлтэй 3,9%, зүүн чиглэлтэй 1,3% байгаагаас үзвэл дийлэнх булшийг баруун хойшоо чиглүүлсэн нь тодорхой байна. Авс хашлага зэргэл модон эдлэлийн үлдэгдэл мэдэгдсэн булш нийт булшны 54,5%-ийг эзэлж байгаа ба үлдсэн хувь нь авсны тодорхой мэдээлэлгүй булшнууд юм. Шагайт чөмөг болон шагай илэрсэн булш 34%, богийн дал болон нурууны яс дагуулсан булш тус бүр 14,9%, бусад төрлийн яс дагуулсан нь 17% тус тус байна. Шагайт чөмгийг энэ бүс нутагт говийн бүстэй харьцуулахад хөл хэсэгт гэхээсээ илүү цээжнээс дээш толгой мөр хавьд байршуулсан нь элбэг харагдана. Харин нурууны ясыг бусад бүсийн дийлэнх булшны ижил хүний нурууны доор байршуулжээ. Далны ясыг тодорхойлж хэлэхэд бэрх байгаа ч цээжнээс дээш биед байршуулсан нь ажиглагдаж байлаа. Дагуулсан эд өлгийн зүйлсийн хувьд богтаг малгайг 12,8%, хутгыг 13,8%, төмөр хайчийг 6,4%, дөрөөг 8,5%, хоромсогыг 3,1%-д тус тус дагуулсан байна.

Бидний судлан буй булшнуудаас хүүхдийн булшинд эд өлгийн зүйл ихэнхдээ дагуулаагүй, зөвхөн зарим нэгэнд нь хойлгын яс дагуулж байсан нь тодорхой болсон ба мөн ганц нэг бүлэг булшны газар хүүхдийн булш давамгайлж байгаагаас үүдээд хүүхэд тавьдаг газар тусдаа байсан уу гэсэн асуулт урган гарч байгааг цаашид судлан үзүүштэй.

Хэлэлцүүлэг

Нийт булшны гүн 100-150 см хооронд хэлбэлзэж байгаа нь монгол булшны соёлын нийтлэг бүрдлийн хувьд анзаарагдам ялгаа биш боловч нүхний гүний хэмжээ бүс нутгаар ялгаатай байна. Хэрлэнгийн сав нутаг бол үндсэндээ монгол орны тал хээрийн бүсэд орших бөгөөд энэ хоёр сав газрын монгол булшны дундаж гүн 1 м орчим байна. Харин ойт хээр, хангай нутаг (Онон, Туул)-т энэ үзүүлэлт бараг 40 см гүн ажээ. Хангай нутгийн хөрс тал хээр, говийн бүсийнхтэй харьцуулахад зөөлөн, элсэрхэг давхарга ихтэй учраас арай гүн ухдаг байж болох магадлал бий боловч угсаатны уламжлалтай холбогдож болно. Хүнээ тавьсан чиглэлийн хувьд Хэрлэн, Тал хээрийн бүсийнхэн бараг тал хувь нь чанх хойд зүг бол хангай нутгийнхан (Онон, Туул, Сэлэнгэ-Тэс (Эг, Хөвсгөл хамт)) талаас илүү нь зүүн хойд зүг рүү хандуулжээ. Хангайн өвөр (Орхон-Тамир), Говийн бүсийн монгол оршуулгад тал хувь нь баруун хойш чиглүүлжээ. Орон нутгийн давамгайлах чиглэлийн хазайлт нь гадаргын онцлогоос хамаараад оршуулгын газраа сонгох ёстой холбоотой байж болно. Тухайлбал, өндөрлөг уулс багатай, тэгш тал зонхилсон Хэрлэнгийн хөндий, тал хээр нутгаар уулсынхаа чанх урд энгэрт, газрын өндөр тал руу толгойг түшүүлэн тавьдаг байхад уужим өргөн ам, хөндий ихтэй хангайд өндөрлөг газрынхаа баруун урд энгэрт, харин говьд мандах наран тосон уулынхаа зүүн урд энгэрт сонгож, газраа бэлддэг байсантай холбоотой бололтой (Өлзийбаяр, Мөнхцэцэг 2025).

Монгол булшинд дагуулсан хойлгын махны яснаас хамгийн их дагуулсан нь шаант чөмөг байгаа нь монголчуудын шагайт чөмгийг хүндэтгэн үзэх, дээдлэх ёстой холбоотой нь дамжиггүй. “...шинээр төрсөн хүүхдийн өлгийд шагай чөмөг зүүх, шинэ хосын хуримын ёслолд хэрэглэх, өндөр настнуудыг хүчээр үхүүлэхэд хэрэглэхээс гадна сая төрсөн хүүхдэд шагай чөмгөний хувь гэж өгөх бөгөөд түүнийг насан туршид нандигнан хадгалах, нас барахад нь дагуулан тавих зэрэг олон ёс заншил” (Батсайхан 2006, 37-56) байдаг. Эндээс үзэхэд, шаант чөмөг оршуулгад төдийгүй, монгол зан үйлэнд чухал байр суурьтай нь харагдаж байна. Түүнчлэн бог малын нурууг ихэвчлэн хүнийхээ нурууны харалдаа доор нь газар хонхойлгон ухаж байрлуулдаг байсан нь, мөн ихэнхдээ нурууны тоо 2-4 хооронд байгаа нь, зарим оршуулгад далыг давхар дагуулсан зэрэг нь эртний нүүдэлчдийн ямар нэгэн зан үйлтэй холбоотой гэдэг нь таамаглал төдий байна.

Дүгнэлт

Аливаа улс үндэстний түүх соёлыг судлахад бичгийн сурвалж болон археологийн олдвор гол тулгуур нь болдог. Археологийн олдвор нь соёлын бие болон биет бус өвийн талаарх мэдээлэл агуулж байдгийг шинжлэх ухааны салбарууд тус тусын хүрээнд судлан боловсруулах нь чухал ач холбогдолтой юм. Монгол нутагт малтан судалсан дундад зууны үеийн булш оршуулгын хэрэглэгдэхүүнийг 1920-оод оноос 2020 он хүртэлх 100 орчим жилээр тоймлон, бүс нутгаар ангилан авч үзсэн нь оршуулгын зан үйл, олдворын мэдээллийг нэгтгэн харах боломжийг бүрдүүлж байна. Газар нутгийн онцлогоос хамааруулан найман ай саваар ангилж, тухайн бүс нутгийн оршуулгын зан үйл, олдворын мэдээллийг нэгтгэн харуулсан нь оршуулгын соёлын мэдээллийг бүс нутгаар нь харьцуулах боломжийг олгож байна.

Ашигласан материалын жагсаалт

- Батдалай, Б. 2024. “X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол Улсад малтсан хэрэглэгдэхүүнээр).” Ph.дисс., Монгол Улсын их сургууль.
- Батсайхан, З. 2006. “Шарга, Ачаат ууланд хийсэн археологийн судалгаа.” *Mongolian journal of Anthropology, Archaeology and Ethnology* Vol. 2, №2 (271): 37-56.
- Волков, В.В. 1962. “Эртний монгол булш.” *БНМАУ-ын ШУА-ийн мэдээ*. №4: 66-67.
- Лхагвасурэн, Х. 1994. “Средневековые погребения монголов (XII-XIV вв.).” Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Москва.
- Лхагвасүрэн, Х. 2007. *Монголын археологи (Чингэс хааны үе)*. Улаанбаатар.
- Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. 2003. *Монгол Улсын түүх. Тэргүүн боть*. Ред. Далай Ч., Ишдорж Ц. Улаанбаатар: Admon.
- Өлзийбаяр С., Мөнхцэцэг О. 2025. “Монгол булшны судалгааны түүхийн үечлэл ба “дундад үеийн монголчуудын оршуулгын соёл” мэдээллийн сангийн үзэл баримтлал.” *Эзэнт гүрний үеийн монголчуудын үнэт зүйлс, соёл, сэтгэлгээг баримтаар мөшгөхүй*, Ер. ред. Алтанцэцэг Ч., Энхчимэг Ц., Золзаяа М. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Түвшинжаргал, Т. 2012. “Дундад эртний үеийн булшинд бог малын нуруу дагалдуулах зан үйлийг мөшгөх нь.” *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 7, № 1 (378): 134-142.
- Эрдэнэбат, У. 2007. “Монгол Улсын нутаг дэвсгэрт дундад зууны монголчуудын булш, оршуулгын дурсгалыг судалсан тойм.” *Монгол Улсын Шинжлэх ухаан* 32.